

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цагааннуур тосгоны хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2024/73/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Өлгий хот 2024 он	Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn “Уужим алтай Аудит” ХХК-ны аудитор: В.Хуандых Утас: 99426960 Цахим хаяг: khuash69@gmail.com
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан

 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgi@audit.gov.mn

ЦАГААННУУР ТОСГОНЫ ХҮҮХДИЙН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Ш.ЖАНАР ТАНАА

2024.02.08 № 52
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цагааннуур тосгоны хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цагааннуур тосгоны хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан 1,370.3 сая төгрөгийн өртөгтэй цэцэрлэгийн шинэ барилгыг ашиглалтад хүлээн авсан байна.

Аудитын гол асуудал

2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд анхаарал татах асуудал байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторовын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

00402035

Цагааннуур цэцэрлэг Дүгнэлт

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



ЖАЙГУЛ

Цагааннуур цэцэрлэг Дүгнэлт

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан****АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	33841812.20	91518248.84
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	8316370.00	60388401.95
31211	Төрийн сангийн харилцах	8316370.00	60388401.95
33	АВЛАГА	0.00	706978.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0.00	706978.00
35	БАРАА МАТЕРИАЛ	25525442.20	30422868.89
35410	Бичиг хэргийн материал	2178200.00	2000000.00
35420	Аж ахуйн материал	14399212.00	18989412.00
35440	Түлш, шатах тослох материал	1390373.10	880001.10
35460	Хүнсний материал	4488914.10	5484712.79
35470	Бусад хангамжийн материал	3068743.00	3068743.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	688185438.27	2050936484.95
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	688185438.27	2050936484.95
391	Газар	0.00	0.00
392	Биет хөрөнгө	684479438.27	2045854687.25
39201	Барилга, байгууламж, орон сууц	827053389.00	2197337035.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	-
		163169938.18	-217592709.53
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	30108426.67	58284616.67
39206	Хуримтлагдсан элэгдэл	-12533174.05	-18081387.14
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	12463310.00	37105670.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-11295128.17	-13051090.75
39214	Бусад үндсэн хөрөнгө	1950000.00	1950000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1950000.00	-1950000.00
39216	Дуусаагүй барилга, байгууламж	0.00	0.00
39217	Ном	1852553.00	1852553.00
393	Биет бус хөрөнгө	3706000.00	5081797.70
39301	Програм хангамж	550000.00	1973239.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-550000.00	-597441.30
39303	Бусад биет бус хөрөнгө	3706000.00	3706000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	722027250.47	2142454733.79
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	722027250.47	2142454733.79
51	Засгийн газрын хувь оролцоо	722027250.47	2142454733.79
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	56242726.00	56242726.00
51101	Өмч: - төрийн	56242726.00	56242726.00
51102	- хувийн	0.00	0.00
512	Хуримтлагдсан үр дүн	-73746048.05	1346681435.27
51210	Өмнөх үеийн үр дүн	-73746048.05	-73746048.05
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	1420427483.32
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	0.00	0.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	739530572.52	739530572.52
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	722027250.47	2142454733.79

Цагааннуур тосгоны хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
			/Төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	356,965,400.00	1,957,958,410.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	1,424,135,435.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	-	1,424,135,435.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	316,954,100.00	484,836,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	316,954,100.00	484,836,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	103,500.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	103,500.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	39,907,800.00	48,986,075.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	39,907,800.00	48,986,075.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	385,229,915.41	537,530,926.68
21	УРСГАЛ ЗАРДАЛ	385,229,915.41	537,530,926.68
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	385,126,415.41	537,110,926.68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	248,338,800.00	324,416,920.05
210101	Үндсэн цалин	197,138,251.29	220,710,552.05
210102	Нэмэгдэл	39,620,990.88	90,356,318.00
210104	Урамшуулал	11,579,557.83	13,350,050.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,393,200.00	47,425,600.00
210201	Тэтгэврийн даатгал	22,693,500.00	32,249,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,428,400.00	3,793,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,912,400.00	3,034,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	452,000.00	758,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,906,900.00	7,588,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,714,904.00	47,296,447.00
210301	Гэрэл, цахилгаан	803,016.00	2,063,500.00
210302	Түлш, халаалт	10,581,538.00	43,232,947.00
210303	Цэвэр, бохир ус	1,330,350.00	2,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,724,460.00	-
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	2,724,460.00	-
2105	Нормативт зардал	40,932,914.00	48,115,921.71
210502	Хоол, хүнс	40,932,914.00	48,115,921.71
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	300,000.00	75,500.00
210604	Урсгал засвар	300,000.00	75,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	592,000.00	670,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	592,000.00	670,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	47,130,137.41	69,110,237.92
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,989,900.00	5,346,249.60
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,436,800.00	1,989,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	38,703,437.41	61,774,388.32
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	103,500.00	420,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	103,500.00	420,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(28,264,515.41)	1,420,427,483.32
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)		1,420,427,483.32

Цагааннуур тосгоны хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

(28,264,515.41)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	356965400.00	533822975.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	316954100.00	484836900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	316954100.00	484836900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	103500.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	103500.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	39907800.00	48986075.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	39907800.00	48986075.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	348340030.00	481360943.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	348340030.00	481360943.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	348236530.00	480940943.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	248338800.00	325123898.05
210101	Үндсэн цалин	204184700.00	221417530.05
210102	Нэмэгдэл	36192900.00	90356318.00
210104	Урамшуулал	7961200.00	13350050.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32393200.00	47425600.00
210201	Тэтгэврийн даатгал	22693500.00	32249700.00
210202	Тэтгэмжийн даатгал	2428400.00	3793900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1912400.00	3034900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	612600.00	758900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4746300.00	7588200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13958800.00	47566075.00
210301	Гэрэл, цахилгаан	1563500.00	2513500.00
210302	Түлш, халаалт	10395300.00	43052575.00
210303	Цэвэр, бохир ус	2000000.00	2000000.00
2105	Нормативт зардал	41956730.00	48940870.00
210502	Хоол, хүнс	41956730.00	48940870.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	300000.00	1000000.00
210604	Урсгал засвар	300000.00	1000000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	592000.00	670300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	592000.00	670300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10697000.00	10214200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6167000.00	8203400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4530000.00	2010800.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	103500.00	420000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	103500.00	420000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	8625370.00	52462031.95
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	309000.00	390000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	309000.00	390000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-309000.00	-390000.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00

Цагааннуур тосгоны хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	8316370.00	52072031.95
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		8316370.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	8316370.00	60388401.95

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	56,242,726.00	739,530,572.52	-73,746,048.05		722,027,250.47
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	56,242,726.00	739,530,572.52	-73,746,048.05	0.00	722,027,250.47
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн					0.00
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	56,242,726.00	739,530,572.52	-73,746,048.05	0.00	722,027,250.47
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	56,242,726.00	739,530,572.52	-73,746,048.05	0.00	722,027,250.47
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	56,242,726.00	739,530,572.52	-73,746,048.05	0.00	722,027,250.47
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			1,420,427,483.32		1,420,427,483.32
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	56,242,726.00	739,530,572.52	1,346,681,435.27	0.00	2,142,454,733.79

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		8316370.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	542139375.00	481330943.05

Цагааннуур тосгоны хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

21	УРСГАЛ ЗАРДАЛ	542139375.00	481330943.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	542139375.00	481330943.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	383726800.00	325123898.05
210101	Үндсэн цалин	249085200.00	221417530.05
210102	Нэмэгдэл	120819600.00	90356318.00
210104	Урамшуулал	13822000.00	13350050.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47965500.00	47425600.00
210201	Тэтгэврийн даатгал	32616900.00	32249700.00
210202	Тэтгэмжийн даатгал	3837100.00	3793900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3069400.00	3034900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	767500.00	758900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7674600.00	7588200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	47986075.00	47566075.00
210301	Гэрэл, цахилгаан	2513500.00	2513500.00
210302	Түлш, халаалт	43472575.00	43052575.00
210303	Цэвэр, бохир ус	2000000.00	2000000.00
2105	Нормативт зардал	50186500.00	48940870.00
210502	Хоол, хүнс	50186500.00	48940870.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1000000.00	1000000.00
210604	Урсгал засвар	1000000.00	1000000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	670300.00	670300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	670300.00	670300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10604200.00	10604200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8593400.00	8593400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2010800.00	2010800.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	533822975.00	533402975.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	484836900.00	484836900.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	484836900.00	484836900.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	48986075.00	48566075.00
132001	Орон нутгийн төсвөөс	48986075.00	48566075.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		8316370.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		60388401.95
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
610002	Төсвөөс гадуур байгууллага		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	30.00	30.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	19.00	19.00
620003	Үйлчлэх ажилтан	10.00	10.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	30.0	30.0
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	20.00	20.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	10.00	10.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Цагааннуур тосгоны хүүхдийн цэцэрлэг нь “Цэцэрлэг нь өөрийн ажил үйлчилгээ болон ажилтан албан хаагчдаар дамжуулан гэр бүл, нийгмийн хүрээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, хүүхэдтэй зүй бус харилцах, хамгаалахад хүлээсэн үүрэг, хариуцлагаа биелүүлэх, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэхэд чиглэгдэнэ” гэсэн зорилгын хүрээнд дараах зорилт дэвшүүлэн ажилласан байна.Үүнд:

- Хүүхэд ээлтэй, эцэг эхэд нээлттэй, багаар ажиллаж бүтээлчээр сэтгэдэг эвсэг хамт олон байгууллага болох.
- Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх сургалтын чанарыг сайжруулна.
- Хүүхдийн хүсэл сонирхлыг эрхэмлэн, тоглонгоо хөгжүүлэх

Цагааннуур тосгоны хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Цэцэрлэг нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна.

Улсын Их хурлаас 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдөр Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль хуулийг шинэчлэн баталсан байна.

Засгийн газрын 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн сүлжээнд үнэмлэхгүй хэмжээний өөрчлөлт орсон.

Сангийн сайдын 2023 оны 65 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тушаалаар аккруэл суурьт УСНББОУС-ыг нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг баталсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Боловсролын ерөнхий газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг. Тус цэцэрлэгийн 2023 оны үйл ажиллагаанд Боловсролын ерөнхий газар, Аймгийн Боловсролын газар, аймгийн ЗДТГ-аас шалгалт хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цагааннуур тосгоны хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Цагааннуур тосгоны хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1419.7 сая төгрөгөөр буюу 196.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Цагааннуур тосгоны хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	8316.4	60388.4	52072.0
Авлага	0	707.0	707.0
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	25525.4	30422.9	4897.5
Үндсэн хөрөнгө	688185.4	2050936.5	1362751.1
Нийт хөрөнгө	722027.2	2142454.7	1420427.5
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	722027.2	2142454.7	1420427.5
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	722027.2	2142454.7	1420427.5

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл оны эцэст 60.4 сая төгрөг болж оны эхнээс 52.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүний 59.2 сая төгрөг нь цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн, 1.2 сая төгрөг нь хүүхдийн хоолны зардлын төсвөөс үлдсэн мөнгө байна.

Оны эцэст 0.7 сая төгрөгийн авлагатай гарсан нь цалингийн татварт төсвөөс илүү шилжүүлж авлага үүсгэсэнтэй холбоотой байна.

Бараа материал дансны үлдэгдэл оны эцэст 30.4 сая төгрөг болж 4.9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Хүнсний материал 5.5 сая, аж ахуйн материал 18.9 сая, бичиг хэргийн материал 2.0 сая, түлш, шатах тослох материал 0.9 сая, бусад хангамжийн материал 3.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1420.4 сая төгрөгөөр өссөн нь хөрөнгө оруулалтаар авсан үндсэн хөрөнгө 1424.1 сая төгрөгөөр нэмэгдэж, 61.8 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1420.4 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 1420.4 сая төгрөг гарснаас шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус цэцэрлэгийн 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 472.7 сая, орон нутгийн төсвөөс 49.0 сая, нийт зарлагыг 521.3 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас цэцэрлэгийн 2023 оны хувьсах зардлын төсвийг 361.3 сая төгрөгөөр хянаж, 111.4 сая төгрөгөөр бууруулж баталсан ба төсвийн тодотголоор 123.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 484.8 сая төгрөг болгон тодотгож баталжээ.

Орон нутгийн төсвөөс авах тогтмол зардлын төсвийг 49.0 сая төгрөгөөр баталж, тодотголоор өөрчлөлт ороогүй байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 484.8 сая төгрөгийг улсын төсвөөс, 49.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс нийтдээ 533.8 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 484.8 сая, орон нутгийн төсвөөс 49.0 сая нийтдээ 533.8 сая төгрөгийн санхүүжилт авч 8.3 сая төгрөгийг оны эхний үлдэгдлээс зарцуулсан байна. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 481.3 сая төгрөг буюу 88.7 хувьтай буюу дансанд 60.4 сая төгрөгийн үлдэгдэл гарсан байна. Төсвийн харилцах дансанд их хэмжээний мөнгөний үлдэгдэлтэй гарсан нь төсвийн төлөвлөлт, хуваарилалттай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Цагааннуур тосгоны хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

		/мянган төгрөгөөр/				
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт	
1	81605	Эрүүл мэндийг дэмжих	1005.4	1005.4	0	100%
2	81807	Цэцэрлэгийн хүүхдийн хоол	50186.5	48940.9	1.2	97.5%
3	81816	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	2058.3	2058.3	0	100%
4	81823	Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх	1005.4	1005.4	0	100%
5	81834	Боловсролын стандарт, сургалтын	243130.5	191455.8	51674.7	78.7%
6	81835	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	195767.2	188299.1	7468.1	96.2%
7	80111	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	48986.1	48566.1	420.0	100%
Нийт дүн		542139.4	481331.0	60808.4	88.7%	

Цэцэрлэгийн төсвийн гүйцэтгэл нь төлөвлөснөөс 60.4 сая төгрөгөөр бага гүйцэтгэлтэй гарчээ. Үүнд: цалингийн зардал 58.2 сая, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 1.0 сая, хүүхдийн хоолны зардал 1.2 сая төгрөгөөр төлөвлөснөөс бага гүйцэтгэлтэй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Цэцэрлэг нь тайлант онд нэмэлт төсөв аваагүй байна.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Цагааннуур тосгоны хүүхдийн цэцэрлэг 2023 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Цагааннуур тосгоны хүүхдийн цэцэрлэг нь 2023 онд батлагдсан төсвийн хүрээнд 59.0 сая төгрөгийн бараа материал, 0.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Цагааннуур тосгоны хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит, байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Уужим алтай Аудит” ХХК-ний аудитор В.Хуандых гүйцэтгэж, анхан шатны хяналтыг “Уужим алтай Аудит” захирал Б.Галымбек, дараагийн шатны хяналтыг аудитын менежер Х.Женисбек, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар хэрэгжүүлсэн.

Цагааннуур тосгоны хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

Буянт сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Цагааннуур тосгоны хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 385.2 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 7.7 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 29 шалгуур үзүүлэлтээр горим сорил хэрэгжүүлсэн. Алдаа, зөрчил илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс санхүүгийн тайлангийн аудитын программд орсон мэдээллийн хэрэгжилтийг шалгахад цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийг бүрэн мэдээлсэн байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100%-тай байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланд завсарын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчил илрээгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд 8.3 сая төгрөгийн алдаа¹ илэрч залруулга хийгдсэн. Үүнд: Төсвийн гүйцэтгэлийн тайланд хүүхдийн хоолны зардлыг 8.3 сая төгрөгөөр дутуу тайлагнасныг залруулав.

Аудитаар нийт 61.7 сая төгрөгийн зөрчил² илэрч зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй.

5.2 Албан шаардлага

Аудитаар нийт 8.4 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1.Цэцэрлэг нь 2023 онд хүүхдийн хоол хүнсэнд хүнсний материалын нярвын тайлангаар өдөр бүрийн хоолны талоны дүнгээр нийт 15,788 хүүхдэд 47,497.3 мянган төгрөгийн хүнсний материал зарцуулсан байна. Засгийн газрын 2019 оны 450 дугаар тогтоолоор батлагдсан хүүхдийн нэг өдрийн хоолны зардлын нормоор тооцож үзэхэд жилийн дүнгээр батлагдсан нормыг нийтдээ 8,422.0 мянган төгрөгөөр хэтрүүлэн нормативт зардлыг хэтрүүлэн зарцуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 2019 оны 450 дугаар тогтоолоор батлагдсан хүүхдийн нэг өдрийн хоолны нормативыг баримталж, зөрчлийг арилгаж ажиллах талаар албан шаардлага хүргүүлээ.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1.Илрүүлэлт:

Цэцэрлэгийн эрхлэгчийн тушаалаар цалингийн зардлаас ажилтнуудад 12.6 сая төгрөгийн түлээ, нүүрсний хөнгөлөлтийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалт, Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал"¹-тай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврыг мөрдөж, батлагдсан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байдлаар төлөвлөж зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

2. Нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой асуудал

3.1.Илрүүлэлт:

Мэдээлэл технологийн үйлчилгээ 0.7 сая, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх 1.3 сая, түлш халаалтын зардал 38.0 сая, гэрэл цахилгааны зардал 2.1 сая, цэвэр бохир усны зардал 2.0 сая, бараа үйлчилгээний бусад зардал 5.1 сая, нийт 49.2 сая төгрөгийн зардлыг тооцооны данс дамжуулан тооцоо хийгээгүй, шууд зардлаар бүртгэж тайлагнасан.

3.2. Өгсөн зөвлөмж:

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Цагааннуур тосгоны хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, 14.4.2, 20.2, 20.2.5 дахь заалт, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланг бэлтгэх аргачлал, зааврыг мөрдөж аливаа гүйлгээг тооцооны данс дамжуулан бүртгэж тайлагнах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийн гүйцэтгэлийг зөрүүтэй тайлагнасан	1	8,316.3					1	8,316.3				
Дүн	1	8,316.3					1	8,316.3				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цалингийн зардлаас ажилтнуудад түлээ нүүрсний хөнгөлөлт олгосон	1	12,600.0					1	12,600.0				
Зарим зардлыг шууд зардлаар бүртгэж тайлагнасан	1	49,152.8					1	49,152.8				
Хүүхдийн хоолны зардлын батлагдсан нормыг хэтрүүлэн зарлага гаргасан	1	8,422.0			1	8,422.0						
Дүн	3	70,174.8			1	8,422.0	2	61,752.8				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Цагааннуур тосгоны хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								